



# I I I A I E U I I y a y u

021 ai 3.210.526...  
УСХ-ны өчигдрийн мэдээгээр  
Худалдах үнэ 500 төг

2018.06.18. Даваа. №120 (4970)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

**D** www.dardas.mn  
**f** facebook.com/dardas.mn  
**t** twitter.com/MMdardas  
**@** mongollinmedeesonin@gmail.com

- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин



20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Нэргүйн ПУНЦАГБОЛД

## ДОТОР НҮҮРТ

П I - - д а

**ХУЛГАЙД  
ГАР УТСАА  
АЛДСАН ИРГЭД  
ЦАГДААГИЙН  
БАЙГУУЛЛАГАД  
ХАНДААРАЙ**

...Гар утсаа алдсан иргэд манай мөрдөн шалгах хэлтсийн хоёрдугаар байр буюу баруун дөрвөн замын электрон барааны ЭЛБА төвийн хажуу дахь халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст ирж үзэж болно. Ирэхдээ өөрийн алдсан гар утасны и-майл кодыг авч ирэх ёстой...

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## “ХЭН Ч НАМАЙГ ЗАГНАХГҮЙ БАЙГАА НЬ САЙХАН ЮМ”



Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ  
ts.chandmanierdene@gmail.com

Харцных нь гал бөхөж, шингэн шар царайд нь хөнгөн гуниг тогтсон залуухан ээжийн өвөр дээр өөдөж таталдсан бяцхан хүү нь хэвтэнэ. Тээж төрүүлсэн үрээ хөгжлийн бэрхшээлтэй болж, насан туршид нь асарч, дотогшоо эмгэрч явах юм хэмээн зүүдлээ ч үгүй явсаанаа залуухан ээж гунигтайгаа өгүүлсэн юм. Нэгтээ надад ирсэн хувь заяаг үүрээд л гарна даа хэмээн шазуур зуун, уйлах үедээ уйлсаар, нулимс гарахаа болих үед нь амьдралд нь итгэл дагуулсан бүсгүйчүүд гарч иржээ.

- д а y e a e y e i u I V i z z d o



ҮЗЭЛ БОДОЛ

## Н.Энхбаяр ӨРСӨЛДӨӨНД орж ирвэл...



Б.ӨНӨРТӨГТОХ  
baljirunurtogtokh@gmail.com

Нэг жилийн хугацаанд УИХ дахь МАН-ын бүлэг “дотоож”-ны хэрэгт нэр холбогдсон улстөрчөө “гүлдгэр” царайлсаар хамгаалж суусан юм. Нотлох баримтууд нь ар араасаа илэрсэн ч энэ бол гүтгэлэг, залуу улстөрчийг хэлмэгдүүлсэн үйлдэл хэмээн өмгөөлсөөр нэг жилийг барж байлаа. Гэвч тэд үнэнд гүйцэгдэв. Улстөрчийнх нь үйлдэл прокуророос яллах дүгнэлт үйлдэх хэмжээнд хүрсний

дараа арайхийн “дотоож”-оо тайлах шийдвэрийг хоёр долоо хоног хэлэлцэн байж гаргалаа. Бүлэг дотроо зодолдож, хамгаалсан улстөрчид нь хагаралдаж юм юм л болов, энэ хугацаанд. Эмэгтэй гишүүд нь хүртэл соошлоор “ам нээсэн дээрээ уушги нээлцэе” хэмээгээд хүчирхийллийн асуудлаас үүдэн хэрэлдэж, шившгээ тарив.

- д а y e a e y e i u I I I i z z d o

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

## THE GUARDIAN: ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ “MeToo” ХӨДӨЛГӨӨН МОНГОЛД ХҮЧЭЭ АВЛАА



Б.ДАВААХУУ  
Davaakhuu0128@gmail.com

Дэлхийн хэвлэл, мэдээллийн байгууллагууд Монголын тухай, тэр дундаа нийгмийн хөгжил, эдийн засгийн байдал, улс үндэстний тухай хэрхэн мэдээлж буйг “Тэд бидний тухай” булангаараа орчуулан хүргэдэг билээ. Харин энэ удаа “The Guardians” сайтад гарсан Монгол дахь хүчингийн хэргийн тухай буюу АНУ, Европт өрнөсөн эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг Me Too хөдөлгөөн хэрхэн Монголд эхэлсэн талаарх мэдээллийг орчуулан хүргэж байна.

Жилийн өмнө Ч.Саранзаяа руу дүү Наранзаяа нь яаралтай дуудлага хийжээ. Урьд шөнө нь хамт амьдардаг бүсгүй нь гэртээ эрэгтэй найзыгаа авчирч хоносон байна. Улмаар бүсгүйг ажилдаа явахад нь өнөөх эр гэрт нь үлджээ. Харин энэ явдлаас хэдэн цагийн дараа тэрхүү дуудлагыг Наранзаяа эгч рүүгээ хийсэн юм. Тэр үйлж, “Тэр залуу хэн байсан юм бэ. Намайг хүчиндчихээд явчихлаа” хэмээн асуусан байна.

Төд удалгүй тэд тэр эр нь эрх баригч намаас УИХ-д сонгогдсон гишүүн Д.Гантулга байсныг мэджээ.

- д а y e a e y e i u V I I i z z d o

FINE MECHANICAL WATCHMAKING, FROM JAPAN.

PRESAGE

TRIMATIC

Trimatic symbolizes three Seiko inventions that ensure the highest levels of reliability and durability in its mechanical watches.

SEIKO

SEIKO BOUTIQUE - 1	Наран Плаза, 4-р давхар, Чингисийн өргөн чөлөө-29	Утас: 99926756
SEIKO BOUTIQUE - 2	Наран Мола, 2-р давхар, Сөүлийн гудамж -42/1	Утас: 88099991
SEIKO SHOP - 1	Наран Пойнт, Хувьсгалчдын гудамж - 9	Утас: 11-326435
SEIKO SHOP - 2	Наран Центр, УИД-ын баруун талд, Энхтайваны өргөн чөлөө	Утас: 88039397



